



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2" төслийн хүрээнд бий болсон, "Говь-Алтай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 102,440,000.00 (нэг зуун хоёр сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийн балансын үнэ, 40,976,000.00 (дөчин сая есөн зуун далан зургаан мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Увс АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Говь-Алтай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Алтанхуяг, "Увс АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Төмөрчөдөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001151

14-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
237 дугаар тогтоолын хавсралт

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖИЖ БҮЙ "БАНУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР-2" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН "ГОВЬ-АЛТАЙ АЗЗА" ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "УВС АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
18	Toyota Prado 150, 66-06 УБИ (Эйч Кэ Би интернэшнл холдинг ХХК-ашиглагч байгууллагын нэр дээр байгаа)	2020	ш	1	102,440,000.00	40,976,000.00	61,464,000.00
	Нийт дүн			1	102,440,000.00 (нэг зуун хоёр сая дөрвөн зуун дөчин мянга)	40,976,000.00 (дөчин сая есөн зуун далан зургаан мянга)	61,464,000.00 (жаран нэгэн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга)